



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОН-АТОМ ТӨХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/65/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Си Эс Ай Аудит ХХК.
Захирал М.Сэвжидмаа
Утас: 7001981 Цахим хаяг: csi_sevjee@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	14
8.2 Төлбөрийн акт	14
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНЧУ	Бүгд Найрамдах Чех улс
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани



“МОН-АТОМ” ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.ДАЛАЙЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/588
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон-Атом ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мон-Атом ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 853.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "жилийн эцсийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь үнэн, зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт зардлыг 739.7 сая төгрөгөөр тогтоож, Эрдэнэс Монгол ХХК-ийн зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 1,257.9 сая төгрөгийн зардал гарсан байна. Зардлын гүйцэтгэлд 20.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 544.1 сая төгрөгийн зээлийн хүү багтсан бөгөөд эдгээр зардлыг зорилтот түвшний төлөвлөгөөнд оруулж батлаагүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 4 худалдан авах ажиллагаанд 31.3 сая төгрөг төлөвлөснөөс 5 төрлийн бараа ажил үйлчилгээнд 56.1 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд 4 зорилтын хүрээнд 213 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Н.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29,518,235.29	15,162,052.87
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	112,101,274.43	117,002,334.86
1.1.4	Бусад авлага		35,000.00
1.1.6	Бараа материал	11,896,068.68	13,451,477.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	4,400,000.00	400,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	157,915,578.40	146,050,864.81
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	48,210,234.66	75,467,617.04
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,670,664,180.00	1,670,664,180.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1,927,177,212.00	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,646,051,626.66	1,746,131,797.04
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,803,967,205.06	1,892,182,661.85
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,734,132,393.76	248,737,683.59
2.1.1.2	Цалингийн өглөг	53,114,025.24	52,798,355.24
2.1.1.3	Татварын өр	383,000.81	9,975,442.89
2.1.1.4	НДШ-ийн өглөг		11,525,218.87
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл		20,711,100.42
2.1.1.6	Хүүгийн өглөг	1,661,406,390.06	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,449,035,809.87	343,747,801.01
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,453,362,376.24	8,076,215,612.27
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,453,362,376.24	8,076,215,612.27
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,902,398,186.11	8,419,963,413.28
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-Төрийн	100,000,000.00	1,675,192,180.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,575,192,180.00	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(10,773,623,161.05)	(8,202,972,931.43)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(9,098,430,981.05)	(6,527,780,751.43)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,803,967,205.06	1,892,182,661.85

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	94,625,454.55	
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	70,634,000.00	
3	Нийт ашиг (алдагдал)	23,991,454.55	
5	Хүүгийн орлого	690,313.60	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	625,989,786.61	646,583,259.29
11	Санхүүгийн зардал	668,160,254.63	542,386,231.80
12	Бусад зардал	9,366,395.54	12,365,746.37
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(299,225,836.63)	65,999.07
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,578,060,505.26)	(1,201,269,238.39)
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(1,578,060,505.26)	(1,201,269,238.39)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,578,060,505.26)	(1,201,269,238.39)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(1,578,060,505.26)	(1,201,269,238.39)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан /ашиг/	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	1,575,192,180.00	(9,195,74,347.47)	(7,520,282,167.47)
Тайлан үеийн ашиг (алдагдал)			(1,578,148,813.57)	(1,578,148,813.57)
2020 оны 12-р сарын 31	100,000,000.00	1,578,148,813.57	(10,773,623,161.04)	(9,098,430,981.04)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			3,771,919,468.00	3,771,919,468.00
Тайлан үеийн ашиг (алдагдал)			(1,201,269,238.39)	1,201,269,238.39
Өмчид гарсан өөрчлөлт	1,575,192,180.00	(1,575,192,180.00)		
2021 оны 12-р сарын үлдэгдэл	1,675,192,180.00	(1,575,192,180.00)	(8,202,972,931.43)	(6,527,780,751.43)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 30
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.0	Мөнгөн орлогын дүн (+)	124,638,173.37	9.70
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	115,169,954.55	
1.1.4	Буцаан авсан албан татвар	9,462,545.45	
1.1.6	Бусад мөнгөн орлого	5,673.37	9.70
1.2.0	Мөнгөн зарлагын дүн (-)	669,043,784.59	599,133,179.28
1.2.1	Ажиллагчдад төлсөн	312,645,097.00	338,514,560.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	99,731,920.09	98,240,533.14
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	18,811,302.11	19,288,321.45
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	11,504,090.30	8,906,234.01
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	24,189,744.81	5,335,182.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	39,840,219.31	32,926,934.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		518,170.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	162,321,410.97	95,403,244.17
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(544,405,611.22)	(599,133,169.58)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(68,762,727.27)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,706,413.60	1,375,000.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,016,100.00	1,375,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	690,313.60	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	74,535,645.45	70,137,727.27
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,084,545.45	44,972,727.27
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	54,451,100.00	25,165,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(70,829,231.85)	(68,762,727.27)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	610,444,300.00	665,142,553.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	610,444,300.00	665,142,553.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	89,691.46	11,602,838.57
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	89,691.46	11,602,838.57
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	610,354,608.54	653,539,714.43
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,880,234.53)	(14,356,182.42)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,398,469.82	29,518,235.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,518,235.29	15,162,052.87

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө

/ мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалингийн зардал	Мян төг	395,267.5	383,760.0	375,544.4	8,215.6	97.9
2	Ажилтнуудын хоол унааны хөнгөлөлт	Мян төг		36,960.0	23,010.0	13,950.0	62.3
3	НДШ-ийн зардал	Мян төг	54,716.4	53,136.0	58,536.2	(5,400.2)	110.2
4	Түрээсийн зардал	Мян төг	4,480.9	29,400.0	8,977.6	20,422.4	30.5
5	Бичиг хэрэг	Мян төг	3,861.5	10,592.0	5,595.7	4,996.3	52.8
6	Танилцуулга, сурталчилгаа, мэдээлэл	Мян төг	1,760.0	34,500.0	32,404.6	2,095.5	93.93
7	Дотоод сургалт	Мян төг		6,171.2	2,800.0	3,371.2	45.4
8	Томилолт	Мян төг	44,919.1	18,105.0	15,986.3	2,118.7	88.3
9	Зөвлөх үйлчилгээ	Мян төг	38,574.8	46,340.0	69,888.6	(23,548.6)	150.8
10	Судалгааны ажил	Мян төг	240.0	31,200.0	17,273.0	13,927.0	55.4
11	Нийгмийн арга хэмжээ	Мян төг	5,854.0	13,360.0	5,288.2	8,071.8	39.6
12	Харилцаа холбоо	Мян төг	7,263.2	8,160.0	5,422.5	2,737.5	66.5
13	Хурал зөвлөгөөн	Мян төг		7,600.0	897.9	6,702.1	11.8
14	Зочид, төлөөлөгч хүлээн авах зардал	Мян төг	10,483.7	10,000.0	3,521.3	6,478.7	35.2
15	Хангамжийн материал	Мян төг	3,323.6	5,471.0	3,463.7	2,007.3	63.3
16	Шатахуун тээврийн зардал	Мян төг	27,133.5	7,680.0	3,072.9	4,607.1	40.0
17	Магадалшгүй ажлын зардал	Мян төг		6,000.0	5,135.6	864.4	85.6
18	Урсгал зардал үйлчилгээ	Мян төг	7,625.6				
19	Нийт зардлын дүн	Мян төг	597,878.2	708,435.1	636,818.6	71,616.6	89.9
20	Элэгдэл	Мян төг	16,875.6		20,947.3	(20,947.3)	
21	Зээлийн хүүгийн зардал	Мян төг	1,032,647.3		544,110.0	(544,110.0)	
Дүн			1,655,026.5	708,435.1	1201,875.9	(493,440.8)	169.7
1	Компьютер дагалдах хэрэгсэл	Мян төг	20,084.5	17,234.0	12,652.7	4,581.3	73.4
2	Тавилга эд хогшил	Мян төг		4,500.0		4,500	
3	Тоног төхөөрөмж	Мян төг		1,560.0		1,560.	
4	Байгууллагын албан ёсны веб хуудас	Мян төг		8,000.0		7,900.0	
5	Авто машин	Мян төг			35,552.0	(35,552.0)	
Хөрөнгө оруулалтын Дүн			20,084.5	31,294.0	56,104.7	(24,810.7)	179.3
Нийт дүн			1,675,111.1	739,729.2	1,257,980.9	518,251.5	170.1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мон-Атом ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлагын тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, нийгмийн даатгалын хуулийн дагуу шимтгэлийг тооцож суутгаж төлөх, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Си Эс Ай Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Чулуунбат аудитор С.Тогтохсүрэн, Б.Отгончимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын захирал М.Сэвжидмаа хэрэгжүүлсэн.

Мон-Атом ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК нь тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Мон-Атом ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн нийт АХГ-2022/65/НА-СТА-ТӨА

хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүн 3,804.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 38.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Мон Атом ТӨХХК нь төрийн болон цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь заалтын дагуу төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх” үндсэн чиг үүрэгтэйгээр Монгол Улсын засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдсан.

Мон-Атом ТӨХХК-ийн зорилго нь ашигт малтмалын тухай хууль болон цөмийн энергийн тухай хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн эрэл, тандан судалгаа, хайгуулын ажлыг гүйцэтгэн нөөцийг тогтоох, тэдгээрийг олборлох, ашиглах, цөмийн түлш, эрчим хүчний үйлдвэрлэл эрхлэх, тэдгээрт шаардлагатай материаллаг бааз болон үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, энэ салбар дахь гаднын болон хувийн хөрөнгө оруулалттай төслүүдэд төрийн өмчийн оролцоог хэрэгжүүлэхэд оршино.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийг 100.0 хувь төр эзэмшиж байна.

“Мон-Атом”ХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсын нутаг дэвсгэрт уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологийн судалгаа, хайгуул хийх;
- Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг тогтоож, түүнийг өсгөн нэмэх үйл ажиллагаа явуулах;
- Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, боловсруулах;
- Атомын цахилгаан станцад хэрэглэгдэх цөмийн түлшний циклийн зөвшөөрөгдсөн шат дамжлагыг би болгон хөгжүүлэх;
- Монгол Улсын хууль тогтоомж төрийн бодлогын дагуу цөмийн эрчим хүчийг ашиглах, хүчин чадлыг би болгох санал, үндэслэл боловсруулж хэрэгжилтийг хангах;
- Уран, цөмийн эрчим хүчтэй холбогдсон асуудлуудаар гадаад орон, тэдгээрийн компаниудтай бүх төрлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Салбарын чиглэлийн олон улсын улс хоорондын мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах;
- Уран болон цөмийн эрчим хүчний судалгаа, шинжилгээ эрхэлж, үндэсний боловсон хүчнийг бэлтгэж сургах;
- Үйлдвэрлэл үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээх.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Мон Атом ТӨХХК нь 2009 оны 02 дугаар сарын 11-нд Засгийн газрын 45 дугаар тогтоолыг үндэслэн байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн

04 дүгээр тогтоолоор Мон-Атом ТӨХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг Эрдэнэс Монгол ХХК-д шилжүүлж тус компанийн охин компани болсон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй, 5-т “төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ нь хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд үйл ажиллагааны зардал бууруулах арга хэмжээ авч ажилласан.

Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулаагүй Эрдэнэс Монгол ХХК-ийн шийдвэрээр хэвлэл мэдээлэл олон нийттэй харьцах зөвлөх илүү ажиллуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Аж ахуй нэгжийн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоол

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Мон Атом” ТӨХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	29,518.2	15,162.1	(14,356.1)
Авлага	112,101.3	117,037.3	4,936.0
Урьдчилгаа	4,400.0	400.0	(4,000.0)
Бараа материал	11,896.1	13,451.5	1,555.4
Үндсэн хөрөнгө	48,210.2	75,467.6	27,257.4
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,670,664.2	1,670,664.2	
Хайгуул үнэлгээний хөрөнгө	1,927,177.2		(1,927,177.2)
Нийт хөрөнгийн дүн	3,803,967.2	1,892,182.7	(1,911,784.5)
Богино хугацаат өглөг	6,449,035.8	343,747.8	(6,105,288.0)
Урт хугацаат өглөг	6,453,362.4	8,076,215.6	1,622,853.2
Эздийн өмч	100,000.0	1,675,192.2	1,575,192.2
Эздийн өмчийн бусад хэсэг	1,575,192.2		(1,575,192.2)
Хуримтлагдсан ашиг алдагдал	(10,773,623.2)	(8,202,972.9)	2,570,650.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,803,967.2	1,892,182.7	(1,911,784.5)

Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл 0.3 сая төгрөг өмнөх оноос 0.3 сая төгрөгөөр өссөн. Банк дахь харилцах дансны эцсийн үлдэгдэл 14.9 сая төгрөг өмнөх оноос 14.6 сая төгрөгөөр буурсан.

Татвар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 117.0 сая төгрөг өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр өссөн нь НӨАТ-ын авлагаас шалтгаалсан;

Тайлант онд урьдчилж гарсан зардал өмнөх онд 4.4 сая төгрөг, оны эцэст 0.4 сая төгрөг болж буурсан нь тайлант оны ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэн зардалд хүлээн зөвшөөрснөөс шалтгаалсан;

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 75.5 сая төгрөг, өмнөх оноос 27.2 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгийн худалдан авалтаас шалтгаалсан;

Урт хугацаат хөрөнгө оруулалтад охин болон хараат компанийн хувьцаа бүртгэсэн тайлант онд өөрчлөлт гараагүй.

Хайгуул үнэлгээний дансны эхний үлдэгдэл 1,927.2 сая төгрөгөөр буурсан нь Мон-Атом ТӨХХК-ийн эзэмшлийн охин компани болох Мон Чех-Ураниум ХХК-ийн 2021 оны 3 сарын 15-нд болсон ТУЗ-ийн хурлын 2 дугаар тогтоолыг үндэслэн Ураниум Индастри ХК-ийн судалгаа хийлгэх, хамтран ажиллах гэрээний 2.0 сая ам долларын хайгуул үнэлгээний зардлыг Мон-Чех Ураниум ХХК-д хайгуулын зардлаар шилжүүлсэнтэй холбоотой.

Богино хугацаат өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 343.7 сая төгрөг өмнөх оноос 6,105.3 сая төгрөгөөр буурсан нь Эрдэнэс Монгол ХХК-ийн санхүүжилтийн зээлийн хүүгийн өглөг 5,120.5 сая төгрөгийг урт хугацаат зээлд шилжүүлж залруулсан.

Ураниум Индастр ХК-ийн судалгааны ажлын өглөгөөр бүртгэгдсэн 2,201.0 ам доллар буюу 6,271.6 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөрөөс Мон Чех-Ураниум ХХК-ийн 2021 оны 3 сарын 15-нд хуралдсан ТУЗ-ийн хурлын 2 дугаар тогтоолын дагуу хайгуулын зардалд тооцох шийдвэрийн дагуу хасалт хийсэн.

Урт хугацаат өглөгийн үлдэгдэл 8,076.2 сая төгрөг болж өмнөх оноос 1,622.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь богино хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэлтэй байсан Эрдэнэс Монгол ХХК-ийн 5,120.5 сая төгрөгийн зээл, 2,201.5 сая төгрөгийн зээлийн хүүг урт хугацаат зээлийн дансанд залруулсан. Мон Атом ТӨХХК-ийн БНЧУ-ын Ураниум Индастри ХК-д өгөх хайгуул үнэлгээний зардал болох 5,699.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг Мон Чех-Ураниум ХХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр хассантай холбоотой.

Шалгагдагч байгууллагыг толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК нь зээлээр санхүүжүүлдэг бөгөөд зээлийн хүүг жил бүр монгол банкны бодлогын хүүгээр тогтоодог, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зээлийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад ерөнхий удирдлагын зардал 20.6 сая төгрөгөөр өссөн, санхүүгийн зардал 125.8 сая төгрөгөөр буурсан, бусад зардал 3.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мон-Атом ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 сарын 31-ний 04 дугаар тогтоолоор Мон-Атом ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт,

зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт зардлыг 739.7 сая төгрөгөөр тогтоож, Эрдэнэс Монгол ХХК-ийн зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 1,257.9 сая төгрөгийн зардал гарсан байна. Зардлын гүйцэтгэлд 20.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 544.1 сая төгрөгийн зээлийн хүү багтсан бөгөөд эдгээр зардлыг зорилтот түвшний төлөвлөгөөнд оруулж батлаагүй байна. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 4 худалдан авах ажиллагаанд 31.3 сая төгрөг төлөвлөснөөс 5 төрлийн бараа ажил үйлчилгээнд 56.1 сая төгрөг зарцуулсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тухайн байгууллага нь тайлант онд нийт 1,594.7 сая төгрөгийн 35 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 122.9 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн, мэдээлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх асуудал байхгүй

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 44.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 42.7 сая төгрөгийг залруулж, 1.6 сая төгрөгийн зөрчлийг арилгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 243.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн, төлбөрийн акт 100 хувь, зөвлөмж 66.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөг/						Хувь
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	1.6	1	1.6			100.0
Зөвлөмж	3	243.6	2	27.5	1	216.1	66.7
Нийт дүн	4	245.2	3	29.1	1	216.1	83.4

Мон-Зим Интернэйшнл ХХК-тай холбоотой 2013 онд үүссэн өглөг нь эзэн холбогдогч Монгол улсад байхгүй, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь эзэн холбогдогчийн хаягийг тодруулах, өглөг барагдуулах, данснаас хасахаар шүүхээр шийдвэрлүүлэх ажил хангалтгүй байна. Өр төлбөрийг баталгаажуулах, барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хууль эрх зүйн орчин, хувьцааг эзэмшиж байгаа хараат, болон охин компаниудын хувьцаа түүнд тавих хяналтыг авч үзэхээр шийдвэрлэв.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,401.7 сая төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс 7,548.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 2 акт тогтоож, 822.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 153.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн

Залруулагдаагүй 853.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 38.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 7,548.6 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Богино хугацаат өр төлбөрийн дансанд 2,201.5 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг дансны ангилал зөрүү бүртгэж тайлагнасан;
- ТӨХ-ны 2009 оны “Төрийн эзэмшлийн хувийг төрийн төлөөлөлд шилжүүлэх тухай” 207 дугаар тогтоолоор нийт 1,575.2 сая төгрөгийн хувьцааг Мон Атом ТӨХХК-д шилжүүлж өгснийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн;
- Мон Чех Ураниум ХХК-ийн 2021 оны 03 сарын 15-ны хувьцаа эзэмшигчийн хурлын ТУЗ-ын тогтоолоор Ураниум Индастри ХК-ийн санхүүжүүлсэн 2012 оны хайгуул, үнэлгээний зардлыг Мон-Чех Ураниум ХХК-д хайгуулын зардлаар тооцож шилжүүлэн бүртгэх бичилтийг хийсэн боловч бусад зардлыг өмнөх оны үр дүнгээс 3,771.9 сая төгрөгөөр бууруулах бичилт хийгээгүйг өглөгт тус тус залруулсан байна. (Мон Чех Ураниум ХХК-ийн 51 хувийг Мон Атом ТӨХХК, 49 хувийг Ураниум Индастри ХК эзэмшдэг.)

8.2 Төлбөрийн акт

1. Цалингийн тооцооллыг давтан шалгахад цалингаас нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцож суутгаснаас 3 хүний 0.3 сая төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага, ба өр төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулах” гэж заасныг болон үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочийн торгууль 0.1 сая төгрөгийг байгууллагаас төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заасныг болон үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

8.3 Албан шаардлага

1. Мон-Зим Интернишнл ХХК-ийн 216.1 сая төгрөгийн эзэн холбогдогчгүй хөөн хэлэлцэх хугацаа дууссан өглөг данс бүртгэлтэй, өглөгийг барагдуулах шийдвэрлэх, талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Ураниум Индастри ХК-ийн 572.6 сая төгрөг нийт 788.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн эцсийн тайлан гаргахын өмнө" 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь үнэн, зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулах, барагдуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Эрдэнэс Монгол ХХК-ийн 2020 оны 12 сарын 22-ны гүйцэтгэх захирлын Б/177 дугаар тушаалаар хэвлэл мэдээлэл хариуцсан олон нийтийн зөвлөхийн үндсэн цалинг бууруулахгүйгээр хэвлэл, олон нийтийн асуудал хариуцсан зөвлөхөөр шилжүүлэн томилон, авч ажиллуулах үүрэг өгснөөс шалтгаалж зөвлөх үйлчилгээний зардал батлагдсан төсвөөс 33.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо ажиллагсдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцээгүй, хэмжилт, үнэн зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллах, шинээр чиг үүрэг албан тушаал бий болгохгүй байх албан шаардлага хүргүүлэх.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал*

Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгчээс и-баримтаар баталгаажсан төлбөрийн баримтаар гүйлгээ хийгээгүйгээс 29.8 сая төгрөгийн ажил гүйлгээ анхан шатны баримтын шаардлага хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсэхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.3-т "албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасантай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа и-баримт үндэслэн гүйлгээ хийх, НӨАТ-ийн худалдан авалтын баталгаажсан баримттай тулган шалгах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 94 хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар холбогдох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

3. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн тооцооллыг давтан шалгахад 0.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу суутгасан зөрчил илэрсэн.

Энэ нь Нийгмийн даатгалын хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “нийгмийн даатгалын хувь хэмжээ” 17.1 1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэж заасантай нийцээгүй, үнэн зөв бодитой байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

НДШ-ийн тухай хуульд заасан хувь хэмжээний дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож төлөх, тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Мон Атом ТӨХХК	АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Бэлтгэн нийлүүлэгчээс и-баримтаар баталгаажсан төлбөрийн баримтаар гүйлгээ хийгээгүйгээс 29.8 сая төгрөгийн ажил гүйлгээ анхан шатны баримтын шаардлага хангаагүй байна.	Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа е-баримт үндэслэн гүйлгээ хийх, НӨАТ-ийн худалдан авалтын баталгаажсан баримттай тулган шалгах	1	29,750.0									1	29,750.0
2	Мон Атом ТӨХХК	АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 94 ширхэг үндсэн хөрөнгө данс бүртгэлтэй байна.	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар холбогдох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.	1	0									1	

3	Мон Атом ТӨХХК	АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Цалингийн тооцооллыг давтан шалгахад нийгмийн даатгалын шимтгэлийн хувь буруу тооцож суутгаснаас 0.3 сая төгрөгийн цалин илүү олгосон байна.	Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.	1	274.8					1	274.8						
4	Мон Атом ТӨХХК	АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Нийгмийн даатгалын шимтгэлийг давтан шалгахад 0.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл дутуу суутгасан байна.	НДШ-ийн тухай хуульд заасан хувь хэмжээний дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож төлөх, тайлагнах	1	353.5											1	353.5
5	Мон Атом ТӨХХК	АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Мон-Зим Интернишнл ХХК-ийн 216.1 сая төгрөгийн эзэн холбогдогчгүй хөөн хэлэлцэх хугацаа дууссан өглөг данс бүртгэлтэй, өглөгийг барагдуулах шийдвэрлэх, талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Ураниум Индастри ХК-ийн 572.6 сая төгрөг нийт 788.7 сая төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.	1	788,674.1						1	788,674.1					
6	Мон Атом ТӨХХК	АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Богино хугацаат өр төлбөрийн дансанд 2,201.5 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг буруу ангилан бүртгэсэн.	Богино хугацаат өр төлбөрийн дансанд 2,201.5 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг дансны ангилал зөрүү бүртгэж	1	2,201,487.8	1	2,201,487.8										

				тайлагнасныг залруулсан												
7	Мон Атом ТӨХХК	АХГ- 2022/65/НА- СТА-ТӨА	ТӨХ-ны 2009 оны “Төрийн эзэмшлийн хувийг төрийн төлөөлөлд шилжүүлэх тухай” 207 дугаар тогтоолоор нийт 1,575.2 сая төгрөгийн “Төв Азийн уран” ХХК-ийн 21 хувь, “Гурван сайхан” ХХК-ийн 15 хувийн хувьцааг “Мон Атом” ТӨХХК-д шилжүүлж өгснийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн;	ТӨХ-ны 2009 оны “Төрийн эзэмшлийн хувийг төрийн төлөөлөлд шилжүүлэх тухай” 207 дугаар тогтоолоор нийт 1,575.2 сая төгрөгийн эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн	1	1,575,192.2	1	1,575,192.2								
8	Мон Атом ТӨХХК	АХГ- 2022/65/НА- СТА-ТӨА	Мон Чех Ураниум ХХК-ийн 2021 оны 03 сарын 15-ны хувьцаа эзэмшигчийн хурлын ТУЗ-ын тогтоолоор Ураниум Индастри ХК-ийн санхүүжүүлсэн хайгуул үнэлгээ, судалгааны ажилд 2012 оны хайгуул, үнэлгээний болон бусад зардлыг Мон-Чех Ураниум ХХК-д хайгуулын зардлаар тооцож шилжүүлэн бүртгэх бичилтийг тогтоолын дагуу хийсэн боловч өмнөх оны үр дүнг 3,771.9 сая төгрөгөөр бууруулах бичилт хийгээгүй байна.	Өмнөх оны хайгууллага үнэлгээ,судалгааны зардал 3,771.9 сая төгрөгийн залруулага хийх	1	3,771,919.5	1	3,771,919.5								
9	Мон Атом ТӨХХК	АХГ- 2022/65/НА- СТА-ТӨА	Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгуулийн 0.1 сая төгрөгийг байгууллага төлсөн байна.	Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох	1	136.4			1	136.4						

10		АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Эрдэнэс Монгол ХХК-ийн 2020 оны 12 сарын 22-ны гүйцэтгэх захирлын Б/177 дугаар тушаалаар хэвлэл мэдээлэл хариуцсан олон нийтийн зөвлөхийн үндсэн цалинг бууруулахгүйгээр хэвлэл, олон нийтийн асуудал хариуцсан зөвлөхөөр шилжүүлэн томилон, авч ажиллуулах үүрэг өгснөөс шалтгаалж зөвлөх үйлчилгээний зардал батлагдсан төсвөөс 33.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна.	Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллах, шинээр чиг үүрэг албан тушаал бий болгохгүй байх албан шаардлага хүргүүлэх.	1	33,900.0						1	33,900.0							
ДҮН					10	8,401,688.3	3	7,548,599.5	2	411.2	2	822,574.1							3	30,103.5
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																				
1	Мон Атом ТӨХХК	АХГ-2022/65/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 1,594.7 сая төгрөгийн нийт 35 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас 1,417.9 сая төгрөгийн 29 мэдээллийг байршуулж, 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 122.9 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.	1	122,886.0												1	122,886.0	
ДҮН					1	122,886.0												1	122,886.0	
НИЙТ ДҮН					11	8,524,574.3	3	7,548,599.5	2	411,2	2	822,574.1						4	152,989.5	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 106/AOISO053
АХГ 2022/65/НА-СТЯ ТОО
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон Атом ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочийн торгууль 136,363.00 төгрөгийг байгууллагаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Торгуульд төлсөн 136,363.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, ерөнхий нягтлан бодогч Д.Батзаяа нарт хариуцуулав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ АУДИТОР

АКТ ТОГТООСОН:

(Handwritten signatures and stamps)

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

М.СЭВЖИДМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 107/АД/50053
АХГ- 2022/65/НА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон Атом ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн тооцооллыг давтан шалгахад цалингаас нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцож суутгаснаас 274,768.90 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага, ба ер төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 274,768.90 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, ерөнхий нягтлан бодогч Д.Батзаяа нарт хариуцуулав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ АУДИТОР



Д.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

М.СЭВЖИДМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 465/АД/50053
АХГ- 2022/05/НА- СТА ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Мон Атом" ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 12 сарын 22-ны Б/177 дугаар тушаалаар хэвлэл мэдээлэл хариуцсан олон нийтийн зөвлөхийн үндсэн цалинг бууруулахгүйгээр хэвлэл, олон нийтийн асуудал хариуцсан зөвлөхөөр шилжүүлэн томилон, авч ажиллуулах үүрэг өгснөөс шалтгаалж зөвлөх үйлчилгээний зардал батлагдсан төсвөөс 33,900,000.00 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо ажиллагсдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг зөрчин хэрэгжүүлж ажиллаагүй, хэмжилт, үнэн зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан шинээр чиг үүрэг албан тушаал бий болгохгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, ерөнхий нягтлан бодогч Д.Батзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.СЭВЖИДМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 466/АД/50053

Улаанбаатар хот

АХГ-2022/65/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон Атом ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мон-Зим Интернишнл ХХК-ийн 216,065,250.00 төгрөгийн эзэн холбогдогчгүй хөөн хэлэлцэх хугацаа дууссан өглөг данс бүртгэлтэй өглөгийг барагдуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Ураниум Индастри ХК-ийн 572,608,800.00 төгрөг нийт 788,674,050.00 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "Жилийн эцсийн тайлан гаргахын өмнө" 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь үнэн, зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/55 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийг холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, ерөнхий нягтлан бодогч Д.Батзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭВГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.СЭВЖИДМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрог-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\j0.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-155.Docx

0001001304